



# ГАДААД ИРГЭДЭД ЗӨВЛӨГӨӨ ӨГӨХ ГАЗАР

Бид үнэ төлбөргүй зөвлөгөө өгч эмч, сургууль, ажил олгогч, орон сууцны эзэнтэй харьцахад тань дагалдан явж орчуулга хийж туслалцаа үзүүлдэг.

## Бид танд дараахь сэдвээр зөвлөгөө өгөх болно

- Чех улсад оршин суух зөвшөөрлийн талаар
- хөдөлмөр эрхлэлт эсвэл ажил олгогчтой холбоотой асуудлыг шийдвэрлэхэд
- орон сууц
- эрүүл мэндийн халамж, эрүүл мэндийн даатгал
- боловсрол

## Бид таныг дэмжих болно

- албан байгууллагатай харилцахад
- өдөр тутамд тохиолддог асуудалаа шийдвэрлэхэд тань
- санхүүгийн хүндрэлээ шийдвэрлэхэд тань

## Бид дараахь сэдвээр зөвлөгөө өгдөггүй

- татвар, хөрөнгө оруулалт гэх мэт арилжааны үйлчилгээ
- эмнэлзүйн сэтгэл зүйч, гэр бүлийн зөвлөх гэх мэт мэргэжлийн зөвлөхүүдийн үйлчилгээ
- үл хөдлөх хөрөнгийн болоод боловсон хүчний агентлагийн үйлчилгээ
- өмгөөлөгчийн үйлчилгээ, шүүхийн орчуулагчийн эсвэл нотариатын үйлчилгээ

## ТАНЫГ ЮУ ХҮЛЭЭЖ БАЙНА ВЭ

Таньд тулгарсан асуудлыг тань шийдвэрлэхэд бид баяртай туслах болно. Бид та бүхнийг сонсож, цаашид асуудлаа хэрхэн шийдвэрлэх талаар хамтдаа тохиролцоно. Бид танд шаардлагатай мэдээллийг өгч, хийх шаардлагатай алхмуудыг хийхэд тань туслах болно. Таны тулгарсан асуудлаа хэрхэн шийдвэрлэхийг бид үргэлж танд үлдээх болно. Бид таныг тулгарсан асуудлаа аль болох өөрөө бие даан шийдэх боломжийг олгоход чиглүүлэх болно.

Хэрэв та хүсвэл бид үйлчилгээ үзүүлэх талаар тантай бичгээр гэрээ байгуулна. Хэрэв шаардлагагүй бол бид тантай амаар ч тохиролцож болно.

Ажилтан таньд үйлчилгээ үзүүлсэн талаархи тэмдэглэгээ үргэлж бичдэг. Энэ тэмдэглэгээ нь бид ямар нэг чухал зүйлийг марталгүй, тулгарсан асуудлыг тань аль болох хурдан чанартай шийдвэрлэхэд хэрэгтэй байдаг юм. Та хүссэн үедээ ажилтанаас өөрийнхөө тухай бүртгэл тэмдэглэгээг харахыг хүсч болно, хоёр жилийн дараа бид бүртгэлийг бүрмөсөн устгадаг.

Хэрэв та тэмдэглэгээнд нэрээ бичихийг хүсэхгүй байгаа бол бүртгэл тань нэргүйгээр бичигдэх болно.

Хэрэв таньд хувийн уулзалт тохирохгүй бол бидэнтэй утсаар болон имэйлаар холбогдож болно.

Мөн зөвлөгөө өгөх төвийн байрнаас гадна Пардубице хотын нутаг дэвсгэрт бол өөр газарт ч уулзахаар тохирч болох бөгөөд зарим тохиолдолд урьдчилан тохиролцсоны дараа Пардубице аймгийн хүрээнд ч уулзах боломжтой.

Та ямар ч шалтгаан дурьдалгүйгээр манай үйлчилгээг ашиглахаа зогсоож болох ба дараа нь бидэнтэй дахин холбогдох боломжтой.

## БИДНИЙ БАТАЛГАА

- **Хүн бүрт тэгш хандана.** Бид гарал үүсэл, үндэс угсаа, эдийн засгийн байдал, шашин шүтлэг, улс төрийн итгэл үнэмшил гэх мэтээс үл хамааран хүн бүртэй адил тэгш харьцдаг.
- **Хувийн мэдээллийг хамгаална.** Бид таны мэдээллийг хэнд ч дамжуулахгүй нь гарцаагүй. Гэсэн хэдий ч бид хууль ёсны үүрэг хүлээдэг - хэрэв та ноцтой гэмт хэрэг үйлдэх гэж байгаа эсвэл үйлдсэнээ хэлвэл бид цагдаад мэдэгдэх үүрэгтэй.

- **Үнэ төлбөргүй үйлчилнэ.** Манай үйлчилгээ мөн орчуулагч авах нь үнэ төлбөргүй
- **Мэргэжлийн чадвартай ажилтан.** Манай бүх ажилтан нар шаардлагатай боловсрол, мэргэшил эзэмшсэн.
- **Хүний онцлогт тохирсон хандлага.** Бид таны тодорхой нөхцөл байдлыг үргэлж харгалзан үзэх болно.
- **Чөлөөтэй шийдвэр гаргах болон харьцах.** Ажилтан таны нөхцөл байдлыг шийддэггүй, тэр зөвхөн тулгарсан асуудлаа шийдвэрлэх арга замыг таньд санал болгоно.
- **Гомдол гаргах эрх.** Манай үйлчилгээнд сэтгэл хангалуун бус байвал амаар болон бичгээр гомдол гаргаж болно.
- **Өөр ажилтан хүсэх боломжтой.** Хэрэв та өөрт чинь хандаж байгаа ажилтанд сэтгэл хангалуун бус байвал өөр ажилтан хүсэх боломжтой.
- **Тавлаг орчинд хүндэтгэн харьцах.** Уулзалт зөвхөн зөвлөгөө өгч буй ажилтан болоод орчуулагчтай тусдаа өрөөнд явагдана.

## БИД ТАНИАС ЮУ ХҮЛЭЭЖ БАЙНА ВЭ

- тохиролцсон даалгаварын гүйцэтгэл
- зөвлөгөө өгөх газрын ажиллах цагийн хуваарийг хүндэтгэх
- тохиролцсон уулзалтын цагийг дагаж мөрдөх
- манай ажилчидтай зөв боловсон харьцах

Та манай үйлчилгээний талаар дэлгэрэнгүй мэдээлэлийг тухайлбал манай эрхэм зорилго, зарчим зэргийг [mostpro.cz/mongolia](https://mostpro.cz/mongolia) сайтаас авах эсвэл манай ажилтнуудаас асууж болно.



## ХОЛБОО БАРИХ

ВЕБ: [www.mostpro.cz](http://www.mostpro.cz)  
ИМАЙЛ: [info@mostpro.cz](mailto:info@mostpro.cz)  
УТАС: 467 771 170  
ХАЯГ: 17. listopadu 216, Pardubice

Mgr. Kateřina Kotrlá 773 223 453  
Bc. Kateřina Hudáková 774 412 173

## Орчуулагч нар

Англи 774 412 173  
Болгар 774 453 195  
Монгол 739 423 778, 604 270 098  
Румын 725 936 654  
Орос 773 546 329  
Украин 725 936 571

## АЖИЛЛАХ ЦАГИЙН ХУВААРЬ

	9:00–17:00
Даваа	☎ Зөвхөн цаг захиалсан үйлчлүүлэгч
Мягмар	☎ Зөвхөн цаг захиалсан үйлчлүүлэгч
Лхагва	☎ Зөвхөн цаг захиалсан үйлчлүүлэгч
Пүрэв	✗ хаалттай
Баасан	☎ Зөвхөн цаг захиалсан үйлчлүүлэгч



[www.mostpro.cz](http://www.mostpro.cz)

## МАГТААЛ, ГОМДОЛ, ӨӨРЧЛӨЛТИЙН САНААЧЛАГА ХЭРХЭН ИЛЭРХИЙЛЭХ ВЭ

Та манай ажил мөн байгууллагын үйл ажиллагааны талаар бидэнд сэтгэгдэлээ хэлвэл бид баяртай байх болно.

Хэрэв та манай үйлчилгээнд сэтгэл хангалуун бус байвал ГОМДОЛ ГАРГАЖ БОЛНО.

Таны гомдол ямар ч асуудалыг тусгаж болно, жишээлбэл ажилтан танд муу зөвлөгөө өгсөн, тантай эелдэг харьцаагүй, танд хангалттай хугацаа зарцуулаагүй эсвэл ойлгомжтой яриагүй г. м.

Та гомдлоо бичээд шуудангаар илгээж болно (хаяг: 17. listopadu 216, 530 02 Pardubice), эсвэл манай байгууллагын доод давхарын шуудангийн хайрцагт хийж болно (шуудангийн хайрцаг нь байгууллагын нэрээр тэмдэглэгдсэн байдаг Most pro o.p.s.), эсвэл 2 давхарын хаалганы дэргэдэх шуудангийн хайрцагт хийж болно. Та мөн гомдлоо цахим шуудангаар [info@mostpro.cz](mailto:info@mostpro.cz) хаягаар илгээх, дээрх дугааруудын аль нэг рүү залгаж хэлэх эсвэл албан тасалгаанд байгаа ажилчдын аль нэгэнд биечлэн мэдэгдэх боломжтой. Хэрэв та хүсвэл ойр дотны хүн чинь таны өмнөөс гомдол гаргаж болно.

Та гомдол гаргахдаа юунд, хэнд гомдоллож байгаагаа бичиж, тэр үйл явдал хэзээ болсныг тодорхойлно уу. Мөн нэрээ, хаягаа бичнэ үү. Хэрэв та нэр хаягаа бичихийг хүсэхгүй байгаа бол нэрээ нууцалж гомдол гаргаж болно. Та чех, англи, болгар, вьетнам, монгол, румын, орос, украин хэлээр гомдол гаргаж болно. Хэрэв та орчуулагч авчирвал өөр хэлээр гомдол гаргаж бас болно.

Гомдлыг хэн шийдвэрлэх, гомдлын шийдвэрийн талаар танд хэрхэн мэдэгдэхийг манай ажилтан нар танд хэлэх болно. Гомдол шийдвэрлэх хугацаа нь 30 хоног байдаг. Нэргүй гомдлын хариуг 30 хоногийн дотор гаргаж 14 хоногийн хугацаагаар байгууллагын коридорт байрлах мэдээллийн самбарт байршуулна.

Хэрэв та хэрхэн гомдол гаргааа мэдэхгүй байвал манай ажилтнуудаас асуугаарай. Танд баяртай туслах болно. Гомдол гаргаснаас болоод танд бэрхшээл учрахгүй тул та үйлчилгээг цаашдаа ашиглах боломжтой хэвээр байх болно.